



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

**“ТЕЛЕВИЗ, ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ӨӨРИЙН
БҮТЭЭЛИЙН БОЛОН ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ГАДААД,
ДОТООДЫН КОНТЕНТЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН САН” СИСТЕМИЙН
АШИГЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУДЫГ
ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



НЭГ. ТАНИЛЦУУЛГА

1.1. Зорилго, зорилт

Утга зохиол болон урлагийн ажлыг хамгаалах тухай Бернийн конвенц нь 1886 онд байгуулагдаж олон улсын түвшинд зохиогчийн эрхийг хамгаалах эрх зүйн суурь үндсийг тавьж өгсөн ба тухайн цаг үед улс орнууд зохиогчийн эрхийг голдуу хоёр талын гэрээ байгуулан хамгаалдаг байна. Монгол Улсын хувьд 1993 оны 6 дугаар сарын 22-ны өдөр өөрсдийн Зохиогчийн эрхийн тухай хуулийг баталж, улмаар Бернийн конвенцод 1997 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр нэгдэн орсноор уран бүтээлчид гадаадад бүтээлээ хамгаалуулах, гадаадын зохиогчдын эрхийг дотооддоо хамгаалах, зохиогчийн эрхийн зөрчилтэй тэмцэх, оюуны өмчийг хөгжүүлэхэд томоохон нөлөө үзүүлсэн юм.

Орчин цаг үед дэлхий ертөнц даяаршиж, интернэт цахим орчинд хэрэглэгч бүр өөрийн дуртай мэдээллээ оруулж, түгээх боломжтой болсон учраас зохиогчийн эрхийг дижитал эрин үед хамгаалах асуудал уран бүтээлчдэд томоохон хүндрэл учруулсаар байна. Дэлхийн улс орнууд оюуны хулгайтай тэмцэхээр янз бүрийн арга хэмжээ авч байгаа боловч уг асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т заасан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөөнийг дэмжих, оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын үйл ажиллагааг сайжруулах цаашид өргөн нэвтрүүлгийн салбарын бүтээл үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор үйлчилгээ эрхлэгчдийн хүсэлт, Монголын Оюуны Өмч хамгаалах холбоо ГҮТББ-ын санаачилгыг дэмжиж, “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн өөрийн бүтээлийн болон зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй гадаад, дотоодын контентын бүртгэлийн нэгдсэн сан” системийг 2023 онд үүсгэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Дээрх системийг үүсгэснээс хойш 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 43 үйлчилгээ эрхлэгчийн өөрийн бүтээл-725, дотоод бүтээл-493, гадаад бүтээл-1660 бүртгэгдсэн бол 5 ОСДҮЭ-ийн гадаад суваг-216 бүртгэгдсэн байна.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн өөрийн бүтээлийн болон зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй гадаад, дотоодын контентын бүртгэлийн нэгдсэн сан” системийн ашиглалт, үр нөлөө, тулгарч буй асуудлуудыг тодорхойлох судалгаа авч, системийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн бодит судалгаа гаргах, улмаар системийн хэрэглээний байдлыг тодорхойлох зорилготой болно.

Уг судалгааг телевиз болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд 2025 оны 02-р сарын 10-ны өдрөөс 02-р сарын 28-ны өдөр хүртэл нийт 18 хоногийн хугацаатайгаар явуулсан.



1.2. Хамрах хүрээ

Тус системийн ашиглалт, үр нөлөө, тулгарч буй асуудлуудыг тодорхойлох зорилгоор Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт 138 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ) болон телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс судалгаа авах зорилгоор “Google form” ашиглан судалгааны асуулгыг хүргүүлсэн.

Судалгаанд 27 телевизийн үйлчилгээ эрхлэгч, 10 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч оролцсон нь нийт тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн 26%-ийг эзэлж байна.

Харин системд мэдээллээ оруулж буй үйлчилгээ эрхлэгчдийн хувьд 79% нь судалгаанд хамрагдсан үзүүлэлттэй байна.

Систем ашиглаж байгаа үйлчилгээ эрхлэгчдийг ангилан авч үзвэл:

- Системд мэдээллээ оруулж буй 9 ОСДҮЭ бүгд судалгаанд оролцсон - 100%
- Системд мэдээллээ оруулж буй 34 телевизийн 25 нь судалгаанд хамрагдсан нь 73% -ийг бүрдүүлж байна.

Иймээс энэхүү судалгаа нь системд мэдээллээ оруулж буй үйлчилгээ эрхлэгчдийн дунд системийн ашиглалт, үр нөлөөг тодорхойлох зорилгоо хангасан гэж дүгнэж байна.

Судалгааны хамрах хүрээ, хамрагдалтын түвшин нь системийн хэрэглэгчдийн төлөөллийг хангалттай хэмжээнд илэрхийлж байгаа тул үр дүн нь бодит нөхцөл байдлыг тусгахуйц гэж үзэх боломжтой.

Энэхүү судалгааны үр дүн нь нийт тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийг төлөөлөхөөс илүүтэйгээр, **зөвхөн системд мэдээллээ оруулж буй үйлчилгээ эрхлэгчдийн санал, үнэлгээнд тулгуурласан гэж ойлгох нь зүйтэй.**

Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын тоон үзүүлэлтийг дараах хүснэгтээр харуулав:

Судалгаанд хамрагдсан салбарын оролцогч талууд	Үйлчилгээний төрөл	Улаанбаатар хотын үйлчилгээ эрхлэгчдийн хамрагдсан тоо	Орон нутгийн үйлчилгээ эрхлэгчдийн хамрагдсан тоо	Нийт
Телевиз	Өргөн нэвтрүүлгийн телевиз	6	16	21
	Арилжааны телевиз	5	1	6
Олон суваг дамжуулах үйлчилгээ	DVB-T2	4	1	5
	DVB-C2	1	-	1
	DVB-S2	2	-	2
	IPTV	1	-	1
	OTT	1	-	1
Нийт		21	16	37

ХОЁР. ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа 28 ОСДҮЭ-ээс 10 үйлчилгээ эрхлэгч судалгаанд хамрагдсан. Үүнээс 9 нь бүтээлийн мэдээллээ оруулсан үйлчилгээ эрхлэгч байсан бол 1 үйлчилгээ эрхлэгч нь огт мэдээлэл оруулаагүй байна. Судалгаа нь 4 хэсэгтэй нийт 77 асуултаас бүрдэх ба 1-р хэсэгт системтэй холбоотой ерөнхий асуулгууд, 2-р хэсэгт үйлчилгээ эрхлэгчдийн бүтээлийн мэдээллээ оруулах бүртгэлийн цэсүүдтэй холбоотой асуулгууд, 3-р хэсэгт олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжиж байгаа гадаадын телевизийн сувгийг бүртгэхтэй холбоотой асуулгыг тус тус багтаасан бол 4-р хэсэгт системийг сайжруулахтай холбоотой санал авах асуумжуудыг багтаасан.

2.1. Системийг ашиглахтай холбоотой сэтгэл ханамжийн асуулгын хүрээнд:

Судалгаанд хамрагдсан буюу системд мэдээллээ оруулж байгаа үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь системийг ашиглахад сэтгэл ханамжтай буюу 4 гэсэн үнэлгээг өгсөн байна. Үнэлгээ тус бүрийн дундаж хувийг гаргахад хамгийн их хувийг эзэлж байгаа нь Сэтгэл ханамжтай-49% байгаа бол огт сэтгэл ханамжгүй-0% байна.

Хүснэгт 1: Судалгаанд хамрагдсан ОСДҮЭ-ийн сэтгэл ханамжийн тоон үзүүлэлт

Асуумж	Огт сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамжгүй	Дунд	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай	Хэлж мэдэхгүй
Системийн загвар нь хэрэглээнд тохирсон	0%	0%	36.4%	54.5%	0%	18.2%
Хайлт хийх функц нь таны хэрэгцээнд тохирсон	0%	18.2%	9.1%	54.5%	0%	18.2%
Энэ системд ашиглагдаж байгаа нэр, томъёо нь ойлгомжтой	0%	0%	27.3%	63.6%	0%	9.1%
Системийн ерөнхий зохион байгуулалтыг ойлгоход, ашиглахад хялбар	0%	0%	27.3%	45.5%	9.1%	18.2%
Интерфейс нь ойлгомжтой	0%	0%	18.2%	36.4%	18.2%	27.3%
Системийн хариу үйлдэл үзүүлэх хугацаа	0%	0%	9.1%	63.6%	9.1%	18.2%
Системд бүртгэгдсэн бүтээлийн мэдээллүүд ойлгомжтой байдаг	0%	0%	27.3%	27.3%	18.2%	27.3%



Ашигладаггүй
Мэдэхгүй байна

2.4. Системийн цэсүүдийг ач холбогдлоор нь авч үзэхэд:

Системийн цэсүүдийн ач холбогдлын үнэлгээ тус бүрийн дундаж хувийг гаргахад хамгийн их хувийг Сэтгэл ханамжтай-31%, хамгийн бага хувийг Огт сэтгэл ханамжгүй-9.1% эзэлж байна.

Хүснэгт 3: Системийн цэс бүрийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

№	Асуумж	Огт сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамжгүй	Дунд	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай	Хэлж мэдэхгүй
1	Өөрийн бүтээл цэс	9.1%	0%	36.4%	18.2%	9.1%	27.3%
2	Дотоод бүтээл цэс	9.1%	0%	9.1%	45.5%	18.2%	18.2%
3	Гадаад бүтээл цэс	9.1%	0%	9.1%	36.4%	18.2%	27.3%
4	Гадаад суваг цэс	9.1%	0%	9.1%	54.5%	9.1%	18.2%
5	Гадаад сувгийн өргөдөл цэс	9.1%	9.1%	36.4%	27.3%	0%	18.2%
6	Нийтийн зарлал цэс	9.1%	0%	36.4%	27.3%	18.2%	9.1%
7	Санал хүсэлт цэс	0%	0%	54.5%	18.2%	18.2%	9.1%
8	Таны мэдээлэл цэс	0%	18.2%	27.3%	18.2%	18.2%	18.2%
9	Байгууллагын мэдээлэл цэс	9.1%	9.1%	27.3%	36.4%	9.1%	9.1%
10	Байгууллагын хэрэглэгчийн бүртгэл цэс	9.1%	18.2%	27.3%	27.3%	9.1%	9.1%


2.5. Системд өгөгдөл оруулахад бэрхшээлтэй зүйл гарч байсан уу гэх асуулгын хүрээнд ОСДҮЭ-ээс ирүүлсэн мэдээллийг нэгтгэхэд:

Хүснэгт 4: Системд бүтээлийн мэдээлэл оруулахад гарч буй асуудлын хүрээнд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Гарч байгаагүй
Системд хандаж орж чадахгүй байгаа
Контент бүрийн мэдээллийг гараар оруулдаг, excel-р оруулахаар дутуу татагддаг, дутуу татагдсан зөрүүгээ олох, нөхөж оруулах алдаа заах г.м асуудлуудтай ба үүнд хугацаа их шаардаж байна.

2.6. Системийн зорилгыг ойлгож байгаа эсэх асуулгын хүрээнд:

График 2: Системийн ойлголтын талаар асуулгын хүрээнд



2.7. Системд оруулж байгаа мэдээллүүдээс аль хэсгийг нь олон нийтэд хаалттай байлгах хүсэлтэй байгаа талаарх асуулгад:

Хүснэгт 5: Системд бүртгүүлсэн бүтээлийн мэдээллийг хаалттай байлгах тухай үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Хэлж мэдэхгүй байна
Хаалттай байлгах мэдээлэл байхгүй
<ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэгчийн мэдээллийг зөвхөн ХХЗХ болон мэдээлэл оруулж байгаа талд харагддаг байх. 2. Лицензийн хугацааг ХХЗХ болон нийт бүртгэлтэй хэрэглэгчдэд харагддаг байх, хугацааг заавал бөглөж оруулдаг /хх жил, эсхүл хугацаагүй/ байх. 3. Бүх үйлчилгээ эрхлэгчид нь ХХЗХ-оос тогтоосон шаардлагын дагуу мэдээллээ энэхүү системд заавал, үнэ зөв оруулдаг байх. Эс бөгөөс ач холбогдолгүй.
Гэрээний эхлэх, дуусах огноо

2.8. "Өөрийн бүтээл" цэсийг ач холбогдлоор нь авч үзэхэд:

Хүснэгт 6: Өөрийн бүтээл цэсийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

№	Асуумж	Огт сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамжгүй	Дунд	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай	Хэлж мэдэхгүй
1	Бүтээлийн нэр	9.1%	0%	0%	45.5%	27.3%	18.2%
2	Бүтээлийн төрөл	9.1%	0%	9.1%	54.5%	9.1%	18.2%
3	Анх бүтээсэн огноо	9.1%	0%	9.1%	36.4%	27.3%	18.2%
4	Зохиогчийн эрхийн гэрчилгээний дугаар	9.1%	18.2%	9.1%	27.3%	18.2%	18.2%
5	Зохиогчийн эрх эзэмшигчийн нэр	9.1%	9.1%	0%	45.5%	27.3%	18.2%
6	Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах эрхийн төрөл	9.1%	9.1%	0%	45.5%	18.2%	18.2%

Судалгаанд оролцогсдын дийлэнх нь өөрийн бүтээл цэсэд мэдээлэл оруулахад сэтгэл ханамжтай гэж үнэлсэн бөгөөд үнэлгээний дундаж хувь нь 42.4% байгаа бол хамгийн бага нь огт сэтгэл ханамжгүй-9.1% байна.



Өөрийн бүтээл бүртгүүлэхтэй холбоотой гарч байсан асуудлын хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь бүтээл бүртгүүлэхэд асуудал гарч байгаагүй гэж хариулсан.

2.9. “Дотоод бүтээл” цэсийг ач холбогдлоор нь авч үзэхэд:

Хүснэгт 7: Дотоод бүтээл цэсийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

№	Асуумж	Огт сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамжгүй	Дунд	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай	Хэлж мэдэхгүй
1	Бүтээлийн нэр	9.1%	9.1%	9.1%	36.4%	27.3%	9.1%
2	Бүтээлийн төрөл	9.1%	0%	27.3%	36.4%	18.2%	9.1%
3	Гэрээ байгуулсан байгууллага эсвэл дистрибьютер	9.1%	9.1%	27.3%	36.4%	18.2%	9.1%
4	Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах эрхийн төрөл	9.1%	0%	18.2%	27.3%	27.3%	18.2%
5	Зохиогчийн эрх эзэмшигчийн нэр	9.1%	9.1%	18.2%	18.2%	27.3%	18.2%
6	Эрхийн эхлэх огноо	9.1%	0%	27.3%	27.3%	18.2%	18.2%
7	Эрхийн дуусах огноо	9.1%	0%	18.2%	27.3%	27.3%	18.2%

“Дотоод бүтээл” цэсийн ач холбогдлын үнэлгээний дундаж хувийг гаргахад сэтгэл ханамжтай-29.9%, Маш их сэтгэл ханамжтай-23.4%, Дунд-20.8%, Хэлж мэдэхгүй-14.3% байсан бол Огт сэтгэл ханамжгүй болон Сэтгэл ханамжгүй нь 9.1% гэж тус тус хариулсан байна.

Дотоод бүтээл бүртгүүлэхтэй холбоотой гарч байсан асуудлын хүрээнд:

Хүснэгт 8: Дотоод бүтээлийн мэдээлэл бүртгүүлэхэд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Ач холбогдолтой мэдээллүүдийг үнэ зөв, бүрэн гүйцэд оруулдаг байх. Зарим үйлчилгээ эрхлэгчид дутуу оруулж байгаатай холбоотойгоор энэхүү системийн ач холбогдол буурч байна.
Дотоодын бүтээлтэй гэрээ байхгүй
Дотоод бүтээл бүртгүүлэхэд ямар нэгэн асуудал үүсэж байгаагүй
Бүртгүүлж чадахгүй байгаа



2.10. “Гадаад бүтээл” цэсийг ач холбогдлоор нь авч үзэхэд:

Хүснэгт 9: Гадаад бүтээл цэсийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

№	Асуумж	Огт сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамжгүй	Дунд	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай	Хэлж мэдэхгүй
1	Бүтээлийн нэр	9.1%	0%	18.2%	18.2%	36.4%	18.2%
2	Бүтээлийн төрөл	9.1%	0%	27.3%	27.3%	18.2%	18.2%
3	Гэрээ байгуулсан байгууллага эсвэл дистрибьютер	18.2%	0%	18.2%	36.4%	18.2%	9.1%
4	Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах эрхийн төрөл	9.1%	0%	18.2%	36.4%	18.2%	18.2%
5	Зохиогчийн эрх эзэмшигчийн нэр	9.1%	0%	18.2%	27.3%	18.2%	27.3%
6	Эрх эзэмшигчийн харьяалал улс	9.1%	18.2%	9.1%	18.2%	27.3%	18.2%
7	Эрхийн эхлэх огноо	9.1%	0%	27.3%	27.3%	18.2%	18.2%
8	Эрхийн дуусах огноо	9.1%	0%	18.2%	27.3%	27.3%	18.2%

“Гадаад бүтээл” цэсийн ач холбогдлын үнэлгээний дундаж хувийг гаргахад хамгийн их хувийг сэтгэл ханамжтай-27% байгаа бол хамгийн бага хувийг огт сэтгэл ханамжгүй-10% байна.

Гадаад бүтээл бүртгүүлэхтэй холбоотой гарч байсан асуудлын хүрээнд:

Хүснэгт 10: Гадаад бүтээлийн мэдээлэл бүртгүүлэхэд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Контентыг хулгайгаар цацах нөхцөлд ХХЗХ болон холбогдох бусад төрийн байгууллага нь хуульд заасан арга хэмжээг нэн даруу авч байх.
Гэрээтэй гадаад бүтээл байхгүй
Гадаад бүтээл бүртгүүлэхэд ямар нэгэн асуудал үүсэж байгаагүй

2.11. “Гадаад суваг” цэсийг ач холбогдлоор нь авч үзэхэд:

Хүснэгт 11: Гадаад бүтээл цэсийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

№	Асуумж	Огт сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамжгүй	Дунд	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай	Хэлж мэдэхгүй
1	Сувгийн нэр	0%	9.1%	0%	45.5%	27.3%	18.2%
2	Тухайн сувгийн эрхийг эзэмшигч этгээдийн нэр	0%	18.2%	9.1%	45.5%	9.1%	18.2%
3	Эзэмшигчийн харьяалал улс	0%	27.3%	18.2%	36.4%	0%	18.2%
4	Төлбөрийн хэмжээ, төлбөрийн нөхцөл	18.2%	36.4%	9.1%	18.2%	0%	18.2%



5	Сувгийн формат	0%	27.3%	18.2%	36.4%	0%	18.2%
6	Сигналын эх үүсвэр	0%	36.4%	9.1%	36.4%	0%	18.2%
7	Сувгийн төрөлжилт, чиглэл - Монголоор	0%	18.2%	18.2%	36.4%	9.1%	18.2%
8	Хөтөлбөрийн хэл	0%	18.2%	9.1%	36.4%	18.2%	18.2%
9	Сувгийн хөтөлбөр нь зар сурталчилгаатай эсэх	9.1%	36.4%	0%	36.4%	0%	18.2%
10	Үйлчилгээний багц	0%	27.3%	9.1%	45.5%	0%	18.2%
11	Гэрээний төрөл, олгож байгаа эрх	0%	9.1%	0%	63.6%	9.1%	18.2%
12	Гэрээгээр хамрах нутаг дэвсгэрийн хүрээ	0%	9.1%	9.1%	63.6%	0%	18.2%
13	Гэрээ байгуулсан огноо, дуусах огноо тайлбар	0%	9.1%	18.2%	54.5%	0%	18.2%
14	Этгээдийн нэр	0%	18.2%	9.1%	54.5%	0%	18.2%
15	Этгээдийн харьяалал(улс)	0%	36.4%	9.1%	27.3%	9.1%	18.2%

“Гадаад суваг” цэсийн ач холбогдлын дундаж хувийг гаргахад хамгийн их хувийг сэтгэл ханамжтай-42.4%, хамгийн бага хувийг дунд-12.1% байна.

Гадаад сувгийн мэдээлэл бүртгүүлэхтэй холбоотой гарч байсан асуудлын хүрээнд:

Хүснэгт 12: Гадаад сувгийн мэдээлэл бүртгүүлэхэд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Гэрээ байгуулахаар эзэмшигч байгууллагатай холбогдсон боловч хариу имэйл бичдэггүй учир гадаад сувгуудтай гэрээ байгуулж чаддаггүй.
Гадаад суваг бүртгүүлэхэд ямар нэгэн асуудал үүсэж байгаагүй

2.12. Системийг сайжруулахтай холбоотой саналын хүрээнд:

Системийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр:

Хүснэгт 13: Гадаад сувгийн мэдээлэл бүртгүүлэхэд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

<ol style="list-style-type: none"> Оруулж байгаа мэдээллийг олон нийтэд харуулах, бүртгэлтэй хэрэглэгч харах, зөвхөн ХХЗХ харах rule-ээ тодорхой болгох Энэхүү platform-д үйлчилгээ эрхлэгчид мэдээллээ оруулж байгаа нөхцөлд тухайн үйлчилгээ эрхлэгчийн кино сантай таарч байгаа эсэхэд үе үе хяналт тавьж чаддаг байх Өндөр төлбөр төлж, зохиогчийн эрхтэй контентууд авч байгаа ч яг ижил киног хулгайгаар оруулж байгаа тул хохирол амсаж байна. Тухайн газруудыг хааж хяналт тавьж чаддаг бол албан ёсны эрхтэй контентуудаа оруулаад нээлттэй мэдээлээд явах нь зөв. Гэвч бид мэдээллээ орууллаа гээд бусад эрсдэлээ хааж чадахгүй байгаа тул энэ ажил нь тийм ач холбогдолгүй мөртөө хүн цаг их шаардсан ажил болох магадлалтай (Жишээ нь House of Gucci & Vivant зэрэг кино маш өндөр төлбөртэй авч байсан боловч wowkino, lolokino зэрэг веб хуудас дээр хулгайлан гаргах нөхцөлд энэ төрлийн зах зээл хөгжих боломжийг хааж байна.)



4. Үйлчилгээ эрлэгчид мэдээлэл өгөх нөхцөлд хулгайн сайтуудыг domain нэрээр хаадаг байх зохицуулалтыг яаралтай авч хэрэгжүүлэх.
Дистрибьютер компани өөрсдийн нийлүүлсэн контент листийг хэн хэнд өгсөн гэдгээ нөгөө талаас нь оруулах юм уу, чек-лээд явах боломжтой юу? Учир нь бүх контентын эрхийн мэдээллийг үнэн зөв эсэхийг хянах боломжгүй харагдаж байна
Сануулах цэс нэмэлтээр оруулах хүсэлтэй байна. Жишээ нь: Аливаа бүтээлийн эрхийн хугацаа дууссан тохиолдолд шинэчлэх эсвэл хасах тухай мэдэгдэл ирэх.
Гадаад сувгийн гэрээг жижиг аж ахуйн нэгжид хүндрэл учирч байгааг анхаарна уу
Байгуулга бүр бүртгэлээ маш сайн оруулж байх
Элдэв янзын олон мэдээлэл шаардахгүй байвал сайн байна

Системтэй холбоотой биднээс нэмэх эсвэл өөрчлөхийг хүссэн саналын хүрээнд:

Хүснэгт 14: Системтэй холбоотой ОСДҮЭ-ээс ирүүлсэн санал

Илүү энгийн ашиглахад хялбар байлгах
1. Системд оруулах мэдээллийг үнэн зөв, тухай бүр, бүрэн гүйцэд оруулдаг байх. Эс бөгөөс үйлчилгээ эрхлэгчид бусад нь оруулаагүй байх нөхцөлд бид оруулах шаардлага байна уу гэсэн асуудал үүсгэх магадлалтай. 2. Контентыг хулгайгаар түгээж буй талаар мэдээлэл авдаг байх, түүний дагуу хууль бус нөхцөлд domain нэрээр хаадаг байх
Оюуны өмчийн зөрчил дээр ямар арга хэмжээ, хэр хугацаанд авах вэ гэдэгт илүү анхаарч өгнө үү.
Бид гэрээ хийж үндсэн өгөгдлөө оруулж чадахгүй байгаа тул ашиглах боломжгүй байна.
Системд мэдээлэл оруулах хүсэлгүй байна

Систем нь хэр ач холбогдолтой, цаашид үйлчилгээ эрхлэгчид тогтмол ашиглаад явах боломжтой эсэх талаар:

Хүснэгт 15: Системийг цаашид ашиглах боломжтой эсэх асуулгын хүрээнд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Уг системийн мэдээллүүд үнэн зөв болж цэгцрэх, оруулж буй мэдээллүүд нь баяжиж дата бааз үүсэх, түүнчлэн харах эрхийн rule-ийг зохицуулах нөхцөлд ач холбогдолтой.
Хэрэглэхэд боломжтой
Гадаад суваг, бүтээл эзэмшигчидтэй гэрээ байгуулах хүсэлт тавьсан, хүсэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үйлчилгээ эрхлэгчид энэ системд мэдээлэл оруулахад асуудалтай санагдаж байна. Гэрээ байгуулах хүсэлт тавьсан хэдий ч нөгөө талаас гэрээ байгуулахгүй байгаа, гэрээгүй ОСДҮЭ-д нь уг системд мэдээлэл оруулахад хүндрэлтэй харагдаж байна.
Хэрэглэхэд хялбар болгох
Ач холбогдолгүй



ГУРАВ. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТЕЛЕВИЗИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцсон 27 телевизийн үйлчилгээ эрхлэгчийг авч үзэхэд системд бүтээлийн мэдээллээ оруулж байгаа өргөн нэвтрүүлгийн 13 телевизийн 6, арилжааны 9 телевизийн 5, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 16 телевизийн 14 нь хамрагдсан байна. Энэ нь нийт системд мэдээллээ оруулж буй нийт телевизийн 73 % -ийг бүрдүүлж байна.

Асуумж нь 3 хэсэгтэй нийт 54 асуултаас бүрдэх бөгөөд:

- 1-р хэсэг- системтэй холбоотой ерөнхий асуулгууд;
- 2-р хэсэг - үйлчилгээ эрхлэгчдийн бүтээлийн мэдээллийг оруулах бүртгэлийн цэсүүдтэй холбоотой асуулгууд;
- 3-р хэсэг- системийг сайжруулахтай холбоотой санал авах асуулгуудыг тус тус багтаасан.


3.1. Системийг ашиглахтай холбоотой сэтгэл ханамжийн асуулга:

Хүснэгт 1: Судалгаанд хамрагдсан ТВҮЭ-ийн сэтгэл ханамжийн тоон үзүүлэлт

Асуулт	Маш их сэтгэл ханамжтай	Сэтгэл ханамжтай	Дунд	Сэтгэл ханамжгүй	Огт сэтгэл ханамжгүй	Хэлж мэдэхгүй
Системийн загвар нь хэрэглээнд тохирсон	0%	3.7%	18.5%	63%	3.7%	11.10%
Хайлт хийх функц нь таны хэрэгцээнд тохирсон	0%	3.7%	25.9%	59%	7.4%	7.40%
Энэ системд ашиглагдаж байгаа нэр, томъёо нь ойлгомжтой	7.4%	55.6%	18.5%	11.1%	7.4%	7.4%
Системийн ерөнхий зохион байгуулалтыг ойлгоход, ашиглахад хялбар	3.7%	63%	25.9%	0.0%	0.0%	7.4%
Интерфейс нь ойлгомжтой	0.0%	51.9%	33.3%	3.7%	0.0%	11.1%
Системийн хариу үйлдэл үзүүлэх хугацаа	11.1%	59.3%	22.2%	0.0%	0.0%	7.4%
Системд бүртгэгдсэн бүтээлийн мэдээллүүд ойлгомжтой байдаг	7.4%	63%	18.5%	3.7%	3.7%	7.4%



График 1: Судалгаанд хамрагдсан ТВҮЭ-ийн сэтгэл ханамжийн үнэлгээ



Үр дүн: Нийт 7 асуултаас системийн загвар нь хэрэглээнд тохирсон гэх асуултад 66,7% нь сэтгэл ханамжгүй, системийн ерөнхий зохион байгуулалтыг ойлгоход, ашиглахад хялбар байдаг уу гэх асуултад 63% нь сэтгэл ханамжтай, системд бүртгэгдсэн бүтээлийн мэдээллүүд ойлгомжтой байдаг-63% нь сэтгэл ханамжтай гэж тус тус хариулсан байна.

3.2. Системд мэдээлэл оруулахтай холбоотой асуулга.

График 2: Мэдээлэл оруулахтай холбоотой асуулгын хүрээнд



Үр дүн: Нийт 7 асуултаас системд өгөгдөл, мэдээлэл оруулахад хялбар уу? гэх асуултад 77,8% нь тийм, системийг ашиглах явцад ямар нэгэн алдаа гарч байсан уу? гэх асуултад 74,1% нь үгүй, энэ системийг ашигласнаар таны хэрэглээг тодорхой хэмжээнд хангадаг эсэх-85.2% тийм, бусад байгууллагын оруулсан бүтээлийн мэдээллийг харах хэрэгцээ, шаардлага гардаг уу? гэх асуултад 70.4% хувь нь тийм, сэтгэл ханамжтай, системд бүртгэгдсэн бүтээлийн мэдээллүүд ойлгомжтой байдаг-63% сэтгэл ханамжтай гэж тус тус хариулсан байна.

3.3. Системийг ашиглахтай холбоотой бэрхшээлтэй зүйл гарч байсан уу гэх асуулгын хүрээнд ТВҮЭ-ийн ирүүлсэн мэдээллийг нэгтгэн үзүүлэхэд:

Хүснэгт 2: Системийг ашиглахад гарч буй асуудлын хүрээнд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Гарч байгаагүй
Мэдээлэл оруулж буй хүн маш хялбар ажлынхаа цаг заваар хийчихээр олон функцгүй баймаар байна, одоогийн систем ашиглахад маш төвөгтэй сайжруулж хялбархан болгох хэрэгтэй байна
Excel file-аас нэмэлт хийхэд алдаа их гардаг гэж тус тус хариулсан байна

3.4. Системийн цэсүүдийг ач холбогдлоор нь авч үзэхэд:


Хүснэгт 3: Системийн цэс бүрийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

Асуулт	Маш их ач холбогдолтой	Ач холбогдолтой	Дунд	Хэлж мэдэхгүй байна
Өөрийн бүтээл	11.1%	77.8%	3.7%	7.4%
Дотоод бүтээл	14.8%	66.7%	11.1%	7.4%
Гадаад бүтээл	11.1%	59.3%	14.8%	7.4%
Нийтийн зарлал	7.4%	59.3%	18.5%	11.1%
Санал хүсэлт	0%	55.6%	29.6%	14.8%
Таны мэдээлэл	0.0%	63.0%	25.9%	11.1%
Байгууллагын мэдээлэл	3.7%	74.1%	14.8%	7.4%
Байгууллагын хэрэглэгчийн бүртгэл	3.7%	81.5%	7.4%	7.4%

Нийт 10 асуултаас өөрийн бүтээлийн цэс таны хувьд хэр ач холбогдолтой вэ гэх асуултад 77,8% нь ач холбогдолтой, дотоодыг бүтээл-66.7% нь ач холбогдолтой, гадаад бүтээл 59.3% ач холбогдолтой гэж тус тус хариулсан байна.



График 3: Системийн цэс бүрийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв




3.5. Системд өгөгдөл оруулахад бэрхшээлтэй зүйл гарч байсан уу гэх асуулгын хүрээнд ТВҮЭ-ээс ирүүлсэн мэдээллийг нэгтгэхэд:

Хүснэгт 4: Системд бүтээлийн мэдээлэл оруулахад гарч буй асуудлын хүрээнд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Үгүй
Олон шат дараалалтай
Дахин давтан оруулахад бэрхшээлтэй
Хэлж мэдэхгүй байна.

3.6. Системийн зорилгыг ойлгож байгаа эсэх асуулгын хүрээнд:

График 4: Системийн ойлголтын талаар асуулгын хүрээнд



Системийн зорилгыг ойлгож байгаа эсэх асуулгад 13 үйлчилгээ эрхлэгч буюу 48.1% нь маш сайн, 11 үйлчилгээ эрхлэгчийн 40.7% нь дунд зэрэг гэж хариулсан байна.

3.7. Системд оруулж байгаа мэдээллүүдээс аль хэсгийг нь олон нийтэд хаалттай байлгах хүсэлтэй байгаа талаарх асуулгад:

Хүснэгт 5: Системд бүртгүүлсэн бүтээлийн мэдээллийг хаалттай байлгах тухай үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Байгууллагын мэдээлэл
Байхгүй
Гэрээ хийсэн хугацааг хаалттай байлгах
Санхүүгийн үзүүлэлт
Өөрийн болон дотоодын бүтээл
Хувийн мэдээлэл

3.8. “Өөрийн бүтээл” цэсийг ач холбогдлоор нь авч үзэхэд:

Хүснэгт 6: Өөрийн бүтээл цэсийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

Асуулт	Маш их ач холбогдолтой	Ач холбогдолтой	Дунд	Хэлж мэдэхгүй байна
Бүтээлийн нэр	11.1%	63.0%	18.5%	7.4%
Бүтээлийн төрөл	11.1%	63.0%	185.0%	7.4%
Анх бүтээсэн огноо	11.1%	59.3%	18.5%	7.4%
Зохиогчийн эрхийн гэрчилгээний дугаар	7.4%	59.3%	14.8%	11.1%
Зохиогчийн эрх эзэмшигчийн нэр	7.4%	66.7%	14.8%	11.1%
Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах эрхийн төрөл	14.8%	55.6%	18.5%	7.4%

Дээрх 6 асуултад 59-66% нь өөрийн бүтээлд оруулсан цэсүүдийг ач холбогдолтой гэж хариулсан байна. Хэлж мэдэхгүй гэж 7.4-11.1% хэлж мэдэхгүй байна гэсэн байна.

Өөрийн бүтээл бүртгүүлэхтэй холбоотой гарч байсан асуудлын хүрээнд:

Хүснэгт 7: Өөрийн бүтээлийн мэдээлэл бүртгүүлэхэд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Үгүй
Гарч байсан орохгүй удах
Бүтээлийн төрөл"-ийн сонголтыг нэмэгдүүлэх шаардлагатай санагддаг. Кино, баримтат киноны ангилал нэлээд нарийвчлалтай хэдий ч бусад нэвтрүүлгүүдийг багцалсан нь тохиромжгүй.
Минут тооцох нь төвөгтэй гэж тус тус хариулсан байна.-хасах

3.9. “Дотоод бүтээл” цэсийг ач холбогдлоор нь авч үзэхэд:



Хүснэгт 8: Дотоод бүтээл цэсийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

Асуулт	Маш их ач холбогдолтой	Ач холбогдолтой	Дунд	Хэлж мэдэхгүй байна
Бүтээлийн нэр	7.4%	70.4%	14.8%	7.4%
Бүтээлийн төрөл	3.7%	74.1%	14.8%	7.4%
Гэрээ байгуулсан байгууллага эсвэл дистрибьютер	7.4%	70.4%	14.8%	7.4%
Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах эрхийн төрөл	18.5%	51.9%	18.5%	11.1%
Зохиогчийн эрх эзэмшигчийн нэр	11.1%	51.9%	25.9%	11.1%
Эрхийн эхлэх огноо	7.4%	63%	18.5%	11.1%
Эрхийн дуусах огноо	11.1%	63%	18.5%	11.1%

Дотоод бүтээл бүртгүүлэхтэй холбоотой гарч байсан асуудлын хүрээнд судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь бүтээлийн мэдээлэл бүртгүүлэхэд асуудал гарч байгаагүй гэж хариулсан.

3.10. "Гадаад бүтээл" цэсийг ач холбогдлоор нь авч үзэхэд:

Хүснэгт 9: Гадаад бүтээл цэсийг ач холбогдлоор нь авч үзэн хувиар илэрхийлэв

Асуулт	Маш их ач холбогдолтой	Ач холбогдолтой	Дунд	Хэлж мэдэхгүй байна
Бүтээлийн нэр	14.8%	66.7%	11.1%	7.4%
Бүтээлийн төрөл	7.4%	74.1%	11.1%	7.4%
Гэрээ байгуулсан байгууллага эсвэл дистрибьютер	14.8%	59.3%	11.1%	14.8%
Зохиогчийн эрхийн бүтээлийг ашиглах эрхийн төрөл	11.1%	59.3%	14.8%	11.2%
Зохиогчийн эрх эзэмшигчийн нэр	11.1%	59.3%	14.8%	11.1%
Эрх эзэмшигчийн харьяалал улс	3.7%	63.0%	18.5%	11.1%
Эрхийн эхлэх огноо	7.4%	66.7%	7.4%	11.1%
Эрхийн дуусах огноо	14.8%	59.3%	14.8%	11.1%

Дээрх 8 асуултад 59-74% нь гадаад бүтээл цэсэд оруулсан дээрх мэдээллийг ач холбогдолтой гэж хариулсан байна. Хэлж мэдэхгүй гэж 7.4-14.8% хэлж мэдэхгүй гэсэн байна.

Гадаад бүтээл бүртгүүлэхтэй холбоотой гарч байсан асуудлын хүрээнд оролцогчдын дийлэнх хувь нь бүтээл бүртгүүлэхэд асуудал гарч байгаагүй гэж хариулсан байна.

3.11. Системийг сайжруулахтай холбоотой саналын хүрээнд:

Системийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр:



Хүснэгт 10: Гадаад сүвгийн мэдээлэл бүртгүүлэхэд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Мэдэхгүй
Байхгүй
Тогтмол мэдээллээр хангах
Энэхүү систем нь ойлгомжтой хэдий ч хялбар дөхөм ,олон дахин хийх шаардлагагүй байх
Бүтээлийн төрөл, ангиллыг нэмэгдүүлэх
Бүх телевизүүдийг жигд хамруулах. Тоотой хэдэн телевиз бөглөөд бусад нь бөглөхгүй байгаа нь шударга бус, цаашид бөглөх идэвхийг бууруулдаг.
Одоогийн систем ашиглахад төвөгтэй тэр болгон мэдээллээ оруулаад байдаггүй

Системтэй холбоотой биднээс нэмэх эсвэл өөрчлөхийг хүссэн саналын хүрээнд:

Хүснэгт 11: Системтэй холбоотой ТВҮЭ-ээс ирүүлсэн санал

Үгүй, байхгүй
Мэдэхгүй
Минут тооцохыг болиулах-хасах
Амар хялбар ажиллагаа багатай байх
Бүх компаниудыг мэдээллээ оруулах аян өрнүүлэх

Систем нь хэр ач холбогдолтой, цаашид үйлчилгээ эрхлэгчид тогтмол ашиглаад явах боломжтой эсэх талаар:

Хүснэгт 12: Системийг цаашид ашиглах боломжтой эсэх асуулгын хүрээнд үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн санал

Тийм
Мэдэхгүй
Уг нь ач холбогдолтой цаашид ашиглаад явж болно. Өмнө хийсэн бүх бүтээлээ оруулахгүйгээр системд нэвтэрсэн үеэс л мэдээллээ оруулаад явмаар байна.

Дүгнэлт

Тус хороо нь “**Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн өөрийн бүтээлийн болон зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй гадаад, дотоодын контентын бүртгэлийн нэгдсэн сан**” системийн хэрэглээний байдал, цаашид сайжруулах шаардлагыг тодорхойлох зорилгоор телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс судалгаа авсан. Тус судалгаа нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийг бүрэн төлөөлөхгүй бөгөөд **зөвхөн системд мэдээллээ оруулж буй үйлчилгээ эрхлэгчдийн санал, үнэлгээнд тулгуурласан** болно. Тухайлбал



судалгаанд хамрагдсан үйлчилгээ эрхлэгчид нь **системд мэдээллээ оруулж буй нийт үйлчилгээ эрхлэгчдийн 79% -ийг эзэлж байна.**

Иймээс энэхүү судалгаа нь системд мэдээллээ оруулж буй үйлчилгээ эрхлэгчдийн хүрээнд **системийн ашиглалт, үр нөлөө**, цаашид сайжруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгыг тодорхой хэмжээнд хангасан гэж үзэж байна.

Судалгаанд оролцсон буюу **системд мэдээллээ оруулж буй үйлчилгээ эрхлэгчдийн хувьд:**

- Системд мэдээллээ оруулж, системийг ашигласнаар таны хэрэглээг тодорхой хэмжээнд хангадаг эсэх асуултад:
 - Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн 85.2%,
 - Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн 63.6% нь “тийм” гэж хариулсан.
- Бусад байгууллагын оруулсан бүтээлийн мэдээллийг харах хэрэгцээ, шаардлага гардаг эсэх асуултад
 - Телевизийн 63.6%,
 - Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн 45.5% нь “тийм” гэж хариулсан

Эдгээр үр дүнгээс үйлчилгээ эрхлэгчид системд оруулж байгаа мэдээллийг тодорхой хэмжээнд ашиглаж байгаа нь харагдаж байна.

Системийн зорилгыг ойлгож байгаа эсэх асуултад: Судалгаанд оролцогчдын 51.3% нь “маш сайн ойлгож байгаа” гэж хариулсан нь системийн талаарх ойлголт үйлчилгээ эрхлэгчдийн дунд харьцангуй сайн түвшинд байгааг илтгэж байна.

Системийн ашиглалт, сэтгэл ханамжийн үнэлгээ:

Судалгааны дүнгээс харахад оролцогчдын 46% нь системд мэдээллээ оруулахад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн бол 11% нь сэтгэл ханамжгүй гэж хариулсан байна. Харин сэтгэл ханамжгүй гэж хариулсан оролцогчдын ихэнх нь буюу 20.3% нь хайлтын функц нь хэрэгцээнд бүрэн нийцэхгүй байна гэж үзсэн нь тэдний сэтгэл ханамжгүй байдлын гол шалтгаан болж байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь системийн хэрэглээний загвар, интерфэйсийн ойлгомжтой байдал, хариу үйлдлийн хурд зэрэг үзүүлэлтүүдэд эерэг үнэлгээ өгсөн боловч зарим нь ашиглахад төвөгтэй, **олон шат дамжлагатай, алдаа гарах магадлалтай** гэж үзэж байна. Гэхдээ үйлчилгээний төрлөөс хамааран

- **Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид** системийг ойлгомжтой, хялбар ашигладаг гэж дүгнэсэн бол
- Харин **телевизийн үйлчилгээ эрхлэгчид** мэдээлэл оруулах процесс **хэт төвөгтэй, ойлгомжгүй** гэсэн хандлага давамгайлжээ.

Системд мэдээлэл оруулахтай холбоотой үнэлгээний 8 асуулгын дундаж үр дүнг авч үзэхэд—Судалгаанд оролцогчдын 79% нь системийн хэрэглээг хангах байдлыг эерэгээр үнэлсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Гэсэн хэдий ч системийг ашиглахад алдаа гарсан тухай асуултад оролцогчдын 68.8% нь сөрөг

хариулт өгсөн нь системийн үйл ажиллагаатай холбоотой зарим асуудал байгааг илтгэнэ.

Түүнчлэн бүтээлийн төрөл, ангилал нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн нийтлэг санал оролцогчдоос гарчээ.

Системийн цэсүүдийн ач холбогдлын дундаж үнэлгээг авч үзэхэд ОСДҮЭ-ийн хувьд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дунд зэрэгтэй байсан (30.9% нь сэтгэл ханамжтай, огт сэтгэл ханамжгүй гэсэн хариулт 9.1%). Харин телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд системийн цэсүүдийн ач холбогдлыг илүү үнэлсэн бөгөөд 67.1% нь ач холбогдолтой гэж үзжээ. Энэ нь телевизийн үйлчилгээний хэрэглэгчид системийн цэсүүдийг илүү чухал гэж үзсэнийг харуулж байна.

Өөрийн бүтээл, дотоод бүтээл, гадаад бүтээл гэсэн цэсүүдийг оролцогчид өндөр ач холбогдолтой гэж үнэлжээ. Гэвч, системд мэдээлэл оруулахад олон шат дараалалтай, мэдээлэл нэг бүрийг гараар оруулах шаардлагатай, өгөгдөл дутуу татагдах зэрэг хүндрэлүүд тулгарч байгаа нь эдгээр цэсийн ажиллагааг сайжруулах хэрэгцээтэйг илтгэж байна.

Түүнчлэн, системд бүртгэгдсэн зохиогчийн эрхтэй контентуудыг хууль бусаар ашиглах, эсхүл мэдээлэх боломж бүхий хяналтын механизм шаардлагатай байгаа талаар судалгаанд оролцогчид онцолсон.

Судалгаанд оролцогчид системд бүртгэгдсэн бүтээлийн мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал, шүүмжлэл илэрхийлсэн байна. Иймээс олон нийт, бүртгэлтэй хэрэглэгчид болон зохицуулагч байгууллагад хандах мэдээллийн түвшинг тодорхой ялгаж, хандалтын эрхийн түвшинг нарийвчлан зохицуулах шаардлагатайг харуулж байна. Үүнийг техник болон бодлогын түвшинд шинэчлэн боловсронгуй болгосноор системийн хэрэгжилт, үр нөлөө нэмэгдэх ач холбогдолтой гэж үзлээ.

Судалгааны үр дүн болон системийг ашиглахад тулгарч буй асуудлуудыг тус системийг бий болгох талаар санаачилж хүсэлт гаргасан Монголын оюуны өмч хамгаалах холбоонд танилцуулж, асуудлыг хамтран хэлэлцэх улмаар системийн сайжруулалт, ашиглалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөл болон холбогдох талуудын оролцоотой уулзалт зохион байгуулах шаардлагатай гэж үзэв.

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

2025.04.03